


# ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

## ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТАЙЛАН



**Судалгаа Статистикийн газар,  
Судалгааны хэлтэс**

*Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэд, аж ахуй нэгж болон шинжээчдийн эдийн засгийн төлөө байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нэгтгэн тайлагнасан учир Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.*



# ИРГЭДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

## 1-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА  
2018 ОНЫ II УЛИРАЛ

## 1. Иргэдийн Инфляцийн Хүлээлт


Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2018 оны 5 дугаар сарын 14-нөөс 18-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 7 дүүргийн 814 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- Иргэд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2018 оны III улиралд 6.5%, 2019 оны II улиралд 7.4% байхаар; ii) тоон хариултын хувьд 2018 оны III улиралд 4.9%, 2019 оны II улиралд 5% байхаар; iii) мэдрэмж (үнийн өсөлтийг мэдэрч буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2018 оны III улиралд 4.1%, 2019 оны II улиралд 5.9% байхаар тус тус хүлээж байна;
- Иргэд зээлийн хүү ирээдүйд бага зэрэг буурна гэж хүлээж байна;
- Иргэд эдийн засгийн байдал сайжирч, өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн эерэг хүлээлттэй хэвээр байна;
- Иргэдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлттэй хэвээр байна.

### 1.1. Инфляцийн хүлээлт

Чиглэлийн индексээс харахад иргэдийн үнийн өсөлтийн талаарх хүлээлт 2017 оны эхэн үеэс аажмаар өсөж байсан бол 2018 оны 1-р улирлаас эхлэн буурч буй ерөнхий хандлагатай байна. Энэ удаагийн судалгааны үр дүнг 2018 оны I улирлын дүнтэй харьцуулахад үнийн өсөлтийн талаарх иргэдийн хүлээлт бага зэрэг буурчээ. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд инфляци хэвэндээ байна гэсэн хандлага давамгайлж байна /Зураг 1-1/.

Зураг 1- 1. Үнийн өсөлтийн талаарх хандлага /чиглэлийн индекс, ирэх 12 сар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 1- 2. Иргэдийн инфляцийн хүлээлт /чанарын болон тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Иргэдийн инфляцийн хүлээлтийг олон улсын туршлагад тулгуурлан тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход иргэд инфляцийг 2018 оны III улиралд 6.5%, 2019 оны II улиралд 7.4% байхаар хүлээж байна. Харин иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон хариултад тулгуурлан тооцоход 2018 оны III улиралд 4.9%, 2019 оны II улиралд 5%-тай байна. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин */perceived inflation*<sup>2</sup> 2018 оны III улиралд 4.1%, 2019 оны II улиралд 5.9%-тай байхаар тус тус хүлээгдэж байна */Зураг 1-2/*.


Хүлээлтийн чанарын хариултаас харвал иргэдийн 76% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 19% нь үнийн түвшин илүү хурдацтайгаар өснө (өмнөх судалгааны дүнгүүдээс буурсан), 35% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй гэж хариулжээ */Зураг 1-3/*.

Иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултаудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд буюу 2018 оны III улиралд 4.9%, жилийн дараа буюу 2019 оны II улиралд 5%-тай байхаар хүлээж байна. Өөрөөр хэлбэл тоон хариултын хувьд иргэдийн дунд ирэх 12 сарын хугацаанд инфляци өнөөдрийн түвшнээс буурна гэсэн хүлээлт давамгайлж байна */Зураг 1-4/*.


Харин жилийн дараа инфляци 6-8% байна гэсэн хариултыг иргэд хамгийн их давтамжтай өглөө.

<sup>2</sup>-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.

**Зураг 1- 3. Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?**



**Зураг 1- 4. Иргэдийн инфляцийн хүлээлтийн тархалт /тоон хариултаар/**




Эх сурвалж : Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа


Иргэд жилийн дараах хүнсний бус бүтээгдэхүүний инфляцийг 5.1%, хүнсний бүтээгдэхүүний инфляцийг 5.2%-тай байхаар хүлээж байна /*Зураг 1-5*/. Инфляцийн хүлээлтийн талаарх хариултын тархалтаас харахад дараа жилийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт 6-8% байх хариулт хамгийн олон давтамжтай байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 90% нь жилийн дараа буюу 2019 оны II улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн /*Зураг 1-6*/.

**Зураг 1- 5. Инфляцийн хүлээлтийн тархалт /хүнсний, хүнсний бус, ирэх 12 сар/**



**Зураг 1- 6. Инфляцийн хүлээлтийн хуримтлагдсан тархалт /тоон хариултаар/**



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

## 1.2. Эдийн засгийн өсөлт, иргэдийн орлого

Эдийн засгийн чиглэлийн индекс өмнөх улирлын судалгааны дүнгээс бага зэрэг өссөн дүнтэй буюу судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн байдал сайжирна гэсэн эерэг хүлээлттэй хэвээр байна /Зураг 1-7/.

Энэ удаагийн иргэдийн өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индексээс харахад иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-8/.


Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжрахын хэрээр өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

## 1.3. Валютын ханшийн хүлээлт

Валютын ханшийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад 2017 оны I улирлаас эхлэн иргэдийн хувьд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт нэмэгдсэн, улмаар 2018 оны II улиралд явуулсан судалгаагаар иргэдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт өндөр хэвээр байна /Зураг 1-9/.

Гэвч өмнөх 3 улирал (2017.III, 2017.IV, 2018.I)-д явуулсан судалгаатай харьцуулахад ханшийн хүлээлтийн индекс бага зэрэг өссөн буюу чангарна гэсэн хандлага харьцангуй буурч байна.

**Зураг 1- 7. Ирэх 12 сарын эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



**Зураг 1- 8. Өрхийн санхүүгийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



Тайлбар: Чиглэлийн индекс [-1;1] завсарт утгаа авна. [0;1] эдийн засгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна, [0;-1] муудна.

**Зураг 1- 9. Ирэх 12 сарын хугацаанд валютын ханшийн талаарх хүлээлт**



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

### 1.4. Хүүний түвшний ирээдүйн хандлага

2018 оны II улиралд явуулсан судалгаагаар иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү буурна гэсэн хүлээлттэй болсон байна /Зураг 1-10/.


Судалгаанд хамрагдсан иргэдийн дунд ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү буурахгүй гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 1-12/.

Санал асуулгад оролцсон иргэдийн 31% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү өснө гэж үзсэн бол 52% нь хэвэндээ, 17% нь хадгаламжийн хүү буурна гэж хариулжээ /Зураг 1-11/.

**Зураг 1-10. Зээлийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



**Зураг 1-11. Хадгаламжийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



**Зураг 1-12. Хадгаламжийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

# АЖ АХУЙ НЭГЖИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

## 2-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА  
2018 ОНЫ II УЛИРАЛ



## 2. Аж Ахуй Нэгжийн Инфляцийн Хүлээлт

ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРІ” системд суурилан 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 25-ны өдрүүдэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 363 бизнес эрхлэгчдээс санамсаргүй түүврийн аргаар гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- ААН-үүд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2018 оны III улиралд 3.6%, 2019 оны II улиралд 3.6%; ii) тоон хариултын хувьд 2018 оны III улиралд 4.9%, 2019 оны II улиралд 5.2%; iii) мэдрэмж (үнийн өсөлтийг мэдрэч буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2018 оны III улиралд 3.9%, 2019 оны II улиралд 3.6% байхаар тус тус хүлээж байна;
- ААН-үүдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт давамгайлж байна;
- ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байгаа бөгөөд цалингийн түвшин ч мөн бага зэрэг өснө гэж хүлээж байна;
- Түүвэрт хамрагдсан ААН-үүдийн 30 орчим хувь нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинээр ажлын байр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна;

### 2.1. Инфляцийн хүлээлт

Инфляцийн хүлээлтийн талаарх чиглэлийн индексээс харахад энэ улиралд инфляцийн хүлээлт бага зэрэг буурч, үнийн түвшин буурна гэсэн муж руу ойртжээ. Өөрөөр хэлбэл, бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчдийн дунд инфляци өнөөдрийн түвшинд хадгалагдана гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 2.1/.

Зураг 2-1. ААН-ийн үнийн өсөлтийн хүлээлт /чиглэлийн индекс, 12 сарын дараа/



Зураг 2-2. ААН-ийн инфляцийн хүлээлт /чанар ба тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

<sup>1</sup>Өснө, буурна гэсэн хариултуудын зөрүүгээр чиглэлийн индексийг (тэнцлийн статистик) тооцно. Ингэхдээ ААН-үүдээс ирэх 12 сард үнийн өсөлт ямар байх талаар асууж, хариултуудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон.

Аж ахуйн нэгжийн хүлээлтийг олон улсын туршлагад тулгуурлан тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход ААН-үүд инфляцийг 2018 оны III улиралд 3.6%, 2019 оны II улиралд мөн адил 3.6%-тай байхаар хүлээж байна.

ААН-ийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд 4.9%, жилийн дараа буюу 2019 оны II улиралд 5.2%-тай байхаар хүлээж байна. Ирэх оны инфляцийг 4-6 хувьд байна гэсэн хариулт хамгийн өндөр давтамжтай байна /Зураг 2.3/. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин /perceived inflation<sup>2</sup> 2018 оны III улиралд 3.9%, 2019 оны II улиралд 3.6%-тай байхаар хүлээж байна /Зураг 2.2/.


Судалгаанд хамрагдсан ААН-ийн 88% нь 2018 оны III улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн бол 2019 оны II улиралд ААН-ийн 87% нь инфляци зорилтот түвшнээс бага түвшинд байна гэж хүлээжээ /Зураг 2.4/.

## 2.2. Валютын ханш, зээлийн хүүний хүлээлт


Валютын ханшийн чиглэлийн индекс 2012 оноос хойш хандлагаараа буурч ирсэн. Энэ улирал ААН-үүдийн дунд ирэх 12 сарын хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өнөөдрийн түвшнээс чангарна гэх хүлээлт давамгайлж байна. Мөн энэ улирал чиглэлийн индекс өмнөх улиралтай харьцуулахад бага зэрэг буурсан байна /Зураг 2.5/. Энэ нь ААН-үүдийн төгрөгт итгэх итгэл сайн хэвээр байгааг илтгэнэ.

<sup>2</sup>-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.


**Зураг 2-3. ААН-ийн инфляцийн хүлээлт /тархалт, тоон хариултаар/**



**Зураг 2-4. ААН-ийн инфляцийн хүлээлт /хуримтлагдсан тархалт, тоон хариултаар/**



**Зураг 2-5. Ирэх 12 сарын хугацаанд дахь валютын ханшийн хүлээлт**



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

2017 оны IV улиралд зээлийн хүүний чиглэлийн индекс анх удаа сөрөг (зээлийн хүү буурна) утгатай гарсан бол сүүлийн хоёр улирал чиглэлийн индекс өссөн дүнтэй гарлаа. Энэ нь ААН-үүдийн дунд зээлийн хүү ирэх 12 сарын хугацаанд өснө гэсэн хүлээлт давамгайлж байгааг илтгэнэ /*Зураг 2.6/*.

### 2.3. Аж ахуй нэгжийн үйл ажиллагаа

ААН-үүд өнгөрсөн 6 сарын хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт харьцангуй тогтвортой байсан гэж үзжээ. Харин ирэх 6 сарын хугацаанд бизнес эрхлэгчид борлуулж буй барааны эрэлт нь нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна /*Зураг 2.7/*.

Эдийн засгийн хүндрэлээс гарч, бизнесийн идэвхжил бага зэрэг нэмэгдсэнээр ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа тэлэх орон зай үүсч, улмаар ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд ажлын байрыг бага зэрэг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй гэж хариулжээ. Мөн цалинг ирэх 6 сарын хугацаанд бага зэрэг нэмэгдэнэ гэж хүлээж байна /*Зураг 2.8/*


Судалгаанд оролцогч бизнес эрхлэгчдийн 31% нь ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд дийлэнх ААН банкны зээлээр (35%) болон өөрийн хөрөнгөөр (35%) санхүүжүүлнэ гэж хариулсан /*Хавсралт 1-3/*.

Тайлбар: Индекс [-1;1] завсарт утгаа авна. ]0;1] өснө, [0] өөрчлөгдөхгүй, ]0;-1] буурна.

**Зураг 2-6. Ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүүний хүлээлт**



**Зураг 2-7. Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт /өнгөрсөн 6 сар болон ирэх 6 сард/**



**Зураг 2-8. Ирэх 6 сарын хугацаанд ажлын байр болон цалингаа нэмэгдүүлэх эсэх**



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

**ДҮГНЭЛТ, ХАВСРАЛТ**

---

**3-Р БҮЛЭГ**



**ТҮҮВЭР СУДАЛГАА  
2018 ОНЫ II УЛИРАЛ**

### **3. ДҮГНЭЛТ**

#### **3.1. Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт**

Судалгааны үр дүнгээс харахад иргэд 2019 оны II улиралд инфляцийг 5% /тоон хариултын хувьд/, 5.9% /мэдрэмжид суурилсан/, 7.4% /чанарын хариултын хувьд/ тус тус байхаар хүлээж байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарна гэсэн иргэдийн хүлээлт 2017 оны дунд үеэс эхлэн нэмэгдсэн бөгөөд 2018 оны 2 дугаар улирлын судалгаагаар иргэд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш цаашид чангарна гэсэн хүлээлт хэвээр байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү буурна гэсэн хүлээлттэй болжээ.

Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжирч, улмаар орхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

#### **3.2. Аж ахуй нэгжийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт**

ААН-ийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр ААН-үүд 2019 оны II улиралд инфляцийг 3.6% /чанарын хариулт/, 3.6% /мэдрэмжид суурилсан/, 5.2% /тоон хариулт/ тус тус байхаар хүлээж байна.

ААН-ийн 87% нь 2019 оны II улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж хүлээж байна. Инфляцийг 4-6 хувьд байна гэсэн хариулт хамгийн өндөр дамтамжтай байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг чангарна гэж хүлээж байна.


Ирэх 6 сарын хугацаанд ААН-үүд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байна. Бизнес эрхлэгчидийн 30 орчим хувь нь ирэх саруудад үйл ажиллагаагаа тэлэх орон зай үүсч байгаа гэж харж байгаа бөгөөд цалингийн түвшинг өсгөж, ажлын байрыг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

## ХАВСРАЛТ 1.


### Хавсралт 1 : Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцсон нийт иргэдийн 56% нь эмэгтэй, 44% эрэгтэй бөгөөд насны байдлаар нь авч үзвэл 35% нь 18-25, 30% нь 26-35, 19% нь 36-45, 10% нь 46-55, 6% нь 56-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна. /Хавсралт 1-1, Хавсралт 1-2/

Хавсралт 1-1. Хүйс




Хавсралт 1-2. Нас




Мөн судалгаанд оролцогчидийн 36% нь бүрэн дунд, 58% нь дээд боловсролтой бөгөөд тэн хагас нь сард 700.000 төгрөгөөс их зардал гаргадаг байна.

Хавсралт 1-3. Боловсролын түвшин



Хавсралт 1-4. Сарын дундаж зардал




Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

## Хавсралт 2 : Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт

Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2018 оны 5 дугаар сарын 14-нөөс 18-ны өдрүүдэд Монгол Улсын Их Сургууль, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль болон Отгонтэнгэр их сургуулийн оюутнуудтай хамтран Улаанбаатар хотын 7 дүүргийн 814 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалтыг *Хавсралт 2-1*-т үзүүлэв.

### Хавсралт 2-1. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт



### ХАВСРАЛТ 3.

Судалгаанд хамрагдсан нийт 363 аж ахуй нэгж, байгууллагуудыг өмчлөлийн хэлбэрээр авч 135 (37%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 119 (33%) нь бусад хэлбэрийн, 48 (13%) нь хувьцаат компани, 30 (8%) нь нөхөрлөл болон үлдсэн 31 (9%) нь өөр бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй байгууллагууд байлаа (*Хавсралт 3-1*).

#### Хавсралт 3-1. Аж ахуй нэгжийн тоо /өмчлөлөөр/

Аж ахуйн нэгжийн хэлбэр	ТОО	ХУВЬ
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	135	37%
Нөхөрлөл	30	8%
Хоршоо	24	7%
Хувьцаат компани	48	13%
Төрийн өмчит үйлдвэрийн газар	7	2%
Бусад	119	33%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>363</b>	<b>100.0%</b>

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн салбаруудаар ангилан авч үзвэл нийт 363 ААН-ээс үйлчилгээ эрхэлдэг 51%, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 21%, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 3% болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 18% байна (*Хавсралт 3-2*).

#### Хавсралт 3-2. Аж ахуй нэгжийн тоо /салбараар, ажилтны тоогоор/

Салбарын ангилал	Ажилчдын тоо /бүлгээр/					Бүгд
	< 10	11-19	20-49	50-100	101 <	
Хөдөө аж ахуй	0%	0%	0%	0%	1%	1%
Уул уурхай, олборлох	0%	0%	0%	1%	0%	1%
Боловсруулах үйлдвэр	1%	1%	0%	1%	1%	3%
Барилга	0%	0%	0%	0%	1%	3%
Б/Ж худалдаа	16%	1%	0%	1%	1%	21%
Үйлчилгээ	40%	5%	1%	3%	2%	51%
Тээвэр	0%	0%	0%	0%	2%	3%
Бусад	10%	2%	0%	3%	3%	18%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>67.8%</b>	<b>9.0%</b>	<b>1.9%</b>	<b>8.8%</b>	<b>12.6%</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа



Судалгаанд хамрагдсан нийт 363 аж ахуй нэгж, байгууллагуудын дийлэнх буюу 67.8% нь 9 хүртэл ажилчинтай, 9% нь 10-19 ажилчинтай, 1.9% нь 20-49 ажилчинтай, үлдсэн 21.4% нь 50-с дээш ажилчинтай аж ахуй нэгжүүд хамрагджээ (*Хавсралт 3-2*).

Судалгаанд оролцогч ААН-үүдийн дийлэнх буюу 69% нь ирэх 6 сарын хугацаанд компанийнхаа үйл ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөөгүй байна гэж хариулжээ. Харин бизнес эрхлэгчдийн 31% нь ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүний тулд ихэнх ААН банкны зээлээр (35%) болон өөрийн хөрөнгөөр (35%) санхүүжүүлнэ гэж хариулсан байна /*Хавсралт 3-3*/.

### Хавсралт 3-3. Ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагааг өргөжүүлэх эсэх

Санхүүжилтийн хэлбэр	Үйл ажиллагаагаа өргөжүүлэх үү?	
	Тийм	Үгүй
Банкны зээлээр	35%	
Компанийн өөрийн хөрөнгөөр	35%	
Хувьцаа гаргах	2%	
Гадаад эх үүсвэрээр	2%	
Бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр	4%	
Тэтгэлэг, тусламжаар	2%	
Хувь хүнээс зээлэх	8%	
Бусад	12%	
<b>НИЙТ ДҮН</b>	<b>31%</b>	<b>69%</b>

Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

## Хавсралт 3-4. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт

